



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/108/СТА-ТШЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usuhuu83@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

᠑᠗᠑᠐.᠐᠔.᠒1 № 1/᠑54

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ 7

Г ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Р.ГАНТУЛГА ТАНАА 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005070095

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Р.Гантулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 18-наас 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 244 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд хүнд сурталгүй, альваа

чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг, нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдуулсан, цэгцтэй уян хатан бөгөөд үр ашигтай, үйлчилгээг бий болгоно".

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл
- Сум, багаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 397941.6 мянган төгрөгөөс тооцон 7958.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 7958.8 мянган төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 95948,5 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,580.72	34,123.06	11,542.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00	00.00
33	АВЛАГА	598.20	575.54	-22.66
34	УРЬДЧИЛГАА	00.00	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	21,982.52	33,547.52	11,565.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,225,767.93	1,310,174.12	84,406.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,876,632.17	1,841,127.51	-35,504.66
39	ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-650,864.24	-530,953.39	119,910.85
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,248,348.65	1,344,297.17	95,948.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	157.18	157.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,248,348.65	1,344,139.99	95,791.34
51	Засгийн газрын хувь оролцоо	1,248,348.65	1,344,139.99	95,791.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,248,348.65	1,344,297.17	95,948.52

Бараа материалын дансны үлдэгдэл 11565.0 мянган төгрөгөөр өссөн ба сумын ОНХС-ийн 11008.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хаягжуулалт, гэрлэн хаяг зэрэг хөрөнгө бэлтгэснийг бүртгэж, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 3207.4 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө акталсан зэрэг томоохон өөрчлөлтүүд гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 35504,6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын ангилагдаагүй зардлын хөрөнгөөс автомашины үнэ 50000.0 мянга, төсвийн хөрөнгөөр 20.0 мянган үнэ төлбөргүй 141864.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 08 дугаар тогтоолоор 36075.2 мянга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 19/19 дугаар тогтоолоор 191314.0 төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1344297.2 мянган төгрөг болж 95791.3 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн 95791.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 600.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 600.0 мянган төгрөгийн орлогыг үндсэн дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төсөвт байгууллагын өөрийн орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлогоор	600.0	100.0	-500.0	16.7
Нийт дүн	600.0	100.0	-500.0	16.7

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 70106 кодтой нэг хөтөлбөрт зориулан 272583.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 271983.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 600.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 309096.2 мянган төгрөгийн санхүүжилт авч туслах үйл ажиллагааны орлогоос орох 600.0 мянган төгрөгөөс 100.0 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 16.7 хувиар биелүүлсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан авч үзэхэд тайлант онд 510.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 272072.7 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс 271983.2 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зарцуулж 10.5 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд тендерийн баримт бичгийн үнэ 893.5 мянга, аймгийн ангилагдаагүй зардлаас эрх шилжсэн автомашины үнэ 50000.0 мянга, аймгийн ХХААГ-с оготно устгалын санхүүжилт 5760.0 мянга, аймгийн ОНХС-с халуун усны барилгын санхүүжилт 3000.0 мянга, Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-иас хогны хураамж 6666.7 мянга, хамтарсан багийн үйл зардалд 750.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авч 63966.7 мянган төгрөг зарцуулж 3103.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 26 эрсдэл тодорхойлж нийт 26 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 10735.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 118 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээлэлд байршуулснаас хойш дахин засвар хийснээс хугацаа хоцроосон төлөвт орж, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	31	5	
5	Тухай бүр	8	96	70	26	
	Нийт	27	151	118	31	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сумын орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээгүй ЗДТГ-ын нэмэлт дансанд төвлөрүүлж хогны машины жолоочийн цалингийн зардалд 4746.9 мянга, хогны автомашины зардалд 742.5 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8."Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.8.12. "хог хаягдлын үйлчилгээний хураамж" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл: Орон нутгийн төсвийн орлогыг төсөвт байгууллагын нэмэлт дансанд төвлөрүүлэн зарцуулснаар төсвийн үрэлгэн зардал бий болох

1.3. Өгсөн зөвлөмж: Хог хураамжийн орлогыг Орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлж, хуулийг хэрэгжүүлж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид алдааг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас тайлант онд 3600.0 мянган төгрөг зарцуулсан нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөөгүйгээс төсвийн зориулалт бус зарцуулах

- 2.3 **Өгсөн зөвлөмж:** Зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг зарцуулахдаа Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөж ажиллах
- 2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

- 3.1 **Илрүүлэлт:** Цалин, НДШ-ийн зардлыг анхан шатны баримтаас түүвэрлэн давтан тооцоолоход 469.0 төгрөгийн цалингийн санг нийгмийн даатгалын хэлтэст мэдээлээгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.
- 3.2 **Эрсдэл:** Цалингийн санг илүү дутуу мэдээлж өр авлага үүсгэх
- 3.3 **Өгсөн зөвлөмж:** Цалингийн санг тухай бүр нь үнэн зөв мэдээлж, өмнөх оны дутуу мэдээлсэн 469.0 мянган төгрөгийн нөхөн мэдээлж цаашид Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах
- 3.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,580,720.72	34,123,058.34
33	АВЛАГА	598,201.61	575,539.23
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	598,201.61	575,539.23
35	БАРАА МАТЕРИАЛ	21,982,519.11	33,547,519.11
351	Түүхий эд материал	2,670,000.00	3,400,000.00
35110	Тусгай зориулалттай материал	2,670,000.00	3,400,000.00
354	Хангамжийн материал	19,312,519.11	28,647,519.11
35410	Бичиг хэргийн материал	2,096,100.00	1,895,100.00
35420	Аж ахуйн материал	17,216,419.11	25,822,419.11
35440	Түлш, шатах тослох материал	00.00	930,000.00
35600	Мал амьтад	00.00	1,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,225,767,930.45	1,310,174,116.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,225,767,930.45	1,310,174,116.51
392	Биет хөрөнгө	1,213,748,597.04	1,297,498,116.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,216,854,569.28	1,147,255,162.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-274,116,520.38	-120,064,980.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	191,517,152.00	235,634,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-111,187,522.31	-130,008,870.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	164,521,831.40	145,008,997.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-131,611,539.98	-124,831,305.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,837,623.00	88,062,655.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,115,616.44	-56,474,310.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	176,756,992.00	187,956,892.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-83,251,371.53	-99,373,923.49
39216	Дуусаагүй барилга, байгууламж	20,000,000.00	23,770,000.00
39217	Ном	543,000.00	563,000.00
393	Биет бус хөрөнгө	12,019,333.41	12,676,000.00
39301	Програм хангамж	1,675,000.00	950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,581,666.59	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,926,000.00	11,926,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,248,348,651.17	1,344,297,174.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	157,182.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	157,182.00
413	Өглөг	00.00	157,182.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	52,962.00
4136	Бусад өглөг	00.00	104,220.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	18,720.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	85,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,248,348,651.17	1,344,139,992.85
51	Засгийн газрын хувь оролцоо	1,248,348,651.17	1,344,139,992.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	230,672,223.16	230,672,223.16
51101	Өмч: - төрийн	230,672,223.16	230,672,223.16
512	Хуримтлагдсан үр дүн	1,000,876,930.05	1,096,668,271.73
51210	Өмнөх үеийн үр дүн	1,000,876,930.05	1,000,876,930.05
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	95,791,341.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,799,497.96	16,799,497.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,248,348,651.17	1,344,297,174.85

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	469,169,766.00	493,732,918.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,589,505.00	154,679,534.00
120	Нийтлэг татварын бус орлого	72,389,505.00	154,679,534.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	72,389,505.00	154,679,534.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	72,234,505.00	154,579,534.00
122	Тусламжийн орлого	16,200,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	16,200,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	380,580,261.00	339,053,384.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,593,661.00	67,070,184.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,593,661.00	67,070,184.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	302,986,600.00	271,983,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	302,986,600.00	271,983,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	476,893,099.10	394,253,328.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,893,099.10	394,253,328.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	366,507,437.10	389,639,366.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,587,260.39	183,297,651.38
210101	Үндсэн цалин	146,482,293.90	183,297,651.38
210102	Нэмэгдэл	2,104,966.49	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,450,296.00	22,698,032.00
210201	Тэтгэврийн даатгал	29,030,682.00	15,434,664.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,389,391.00	1,815,842.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	275,583.00	1,452,673.00
210204	Ажилгүйдлийн даатгал	69,559.00	363,169.00
210205	Эрүүл мэндийн даатгал	685,081.00	3,631,684.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,026,773.00	16,778,028.00
210301	Гэрэл, цахилгаан	3,305,946.00	11,978,028.00
210302	Түлш, халаалт	10,720,827.00	4,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,965,852.00	42,010,230.00
210401	Бичиг хэрэг	6,266,568.00	6,411,910.00
210402	Тээвэр, шатахуун	18,383,060.00	21,685,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,015,000.00	3,267,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	165,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,301,224.00	10,481,200.00
2105	Нормативт зардал	00.00	4,004,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэргэсэл	00.00	88,100.00
210502	Хоол, хүнс	00.00	3,916,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,002,500.00	275,000.00
210601	Багаж, техник, хэргэсэл	2,000,000.00	275,000.00
210604	Урсгал засвар	2,500.00	00.00
2107	Томиллолт, зочны зардал	5,547,500.00	8,672,900.00
210702	Дотоод албан томиллолт	5,547,500.00	7,966,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	706,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,979,399.00	3,879,516.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,587,799.00	3,735,516.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,600.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,307,000.00	45,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,947,856.71	108,023,309.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,192,570.00	4,233,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	90,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	115,665,286.71	103,790,059.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,385,662.00	4,613,962.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	105,694,673.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	105,694,673.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,190,989.00	10,452.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,190,989.00	10,452.00

**Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,103,510.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,103,510.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-7,723,333.10	99,479,589.50
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,108,330.98	3,688,247.82
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	3,688,247.82
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	24,108,330.98	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-24,108,330.98	-3,688,247.82
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-31,831,664.08	95,791,341.68

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	396,935,261.00	339,153,384.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,355,000.00	100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	155,000.00	100,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	155,000.00	100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	100,000.00
122	Тусламжийн орлого	16,200,000.00	00.00
122001	Хандив тусламж /догоод/	16,200,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	380,580,261.00	339,053,384.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,593,661.00	67,070,184.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,593,661.00	67,070,184.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	302,986,600.00	271,983,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	302,986,600.00	271,983,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	366,545,261.00	339,153,384.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	366,545,261.00	339,153,384.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,398,872.00	334,539,422.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,011,938.00	177,239,200.00
210101	Үндсэн цалин	141,081,537.00	139,898,412.00
210102	Нэмэгдэл	19,930,401.00	31,648,484.00
210104	Урамшуулал	00.00	292,304.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	5,400,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,325,400.00	21,927,500.00
210201	Тэтгэврийн даатгал	13,044,200.00	14,837,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,570,300.00	1,772,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,256,200.00	1,417,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	314,100.00	354,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,140,600.00	3,544,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,269,573.00	18,411,228.00
210301	Гэрэл, цахилгаан	3,045,000.00	3,045,000.00
210302	Түлш, халаалт	13,224,573.00	15,366,228.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,996,400.00	21,193,900.00
210401	Бичиг хэрэг	2,246,380.00	2,506,700.00
210402	Гээвэр, шатахуун	12,459,620.00	16,843,900.00
210403	Шуудан, холбоо, ингернэгийн төлбөр	1,290,400.00	943,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	600,000.00
2105	Нормативт зардал	133,300.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	133,300.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,212,500.00	2,595,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,675,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	250,000.00
210604	Урсгал засвар	537,500.00	2,345,500.00

**Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2107	Томилолт, зочны зардал	5,547,500.00	11,566,500.00
210702	Дотоод албан томилолт	5,547,500.00	7,966,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	3,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,922,861.00	70,525,594.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,234,261.00	67,849,094.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,600.00	22,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,604,000.00	2,604,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,979,400.00	11,080,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,031,400.00	11,080,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	948,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,146,389.00	4,613,962.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	35,455,400.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	35,455,400.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,190,989.00	10,452.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,190,989.00	10,452.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,103,510.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,103,510.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,390,000.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,390,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,390,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,390,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,390,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-30,390,000.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,746,223.16	82,853,327.20	920,364,474.90	1,221,964,025.26
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,746,223.16	82,853,327.20	920,364,474.90	1,221,964,025.26
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	29,490,792.03	29,490,792.03
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	1,000,876,930.05	1,248,348,651.17
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	1,000,876,930.05	1,248,348,651.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	1,000,876,930.05	1,248,348,651.17
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	95,791,341.68	95,791,341.68
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	1,096,668,271.73	1,344,139,992.85

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	272,583,200.00	272,072,748.00	510452.00	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	272,583,200.00	272,072,748.00	510452.00	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271,083,200.00	270,572,748.00	510452.00	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,239,200.00	177,239,200.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	142,107,400.00	139,898,412.00	2208988.00	98.4
210102	Нэмэгдэл	29,731,800.00	31,648,484.00	-1916684.00	106.4
210104	Урамшуулал	00.00	292,304.00	-292304.00	0.0
210105	Гэрээг ажлын хөлс	5,400,000.00	5,400,000.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,927,500.00	21,927,500.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	14,837,900.00	14,837,900.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,772,400.00	1,772,400.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,417,900.00	1,417,900.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	354,500.00	354,500.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,544,800.00	3,544,800.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,413,000.00	18,411,228.00	1772.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,045,000.00	3,045,000.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	15,368,000.00	15,366,228.00	1772.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,193,900.00	21,193,900.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,506,700.00	2,506,700.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	16,843,900.00	16,843,900.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, нингэрэнгийн төлбөр	943,300.00	943,300.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,596,400.00	2,595,500.00	900.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	250,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,346,400.00	2,345,500.00	900.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	11,966,500.00	11,566,500.00	400000.00	96.7
210702	Дотоод албан томилолт	7,966,500.00	7,966,500.00	0.00	100.0
210703	Зочин төлөөлөгч хүдээн авах	4,000,000.00	3,600,000.00	400000.00	90.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,566,700.00	6,558,920.00	7780.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,890,200.00	3,882,420.00	7780.00	99.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,500.00	22,500.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,604,000.00	2,604,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11180000.00	11080000.00	100000.00	99.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,080,000.00	11,080,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	00.00	100000.00	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1500000.00	1500000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	272,583,200.00	272,072,748.00	510452.00	99.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	271,983,200.00	271,972,748.00	10452.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	271,983,200.00	271,972,748.00	10452.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	600,000.00	100,000.00	500000.00	16.7
1200042	Туулах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	100,000.00	500000.00	16.7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	08.00	08.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100.0

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77593661.00	67,070,184.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77593661.00	67,070,184.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74402672.00	63,966,674.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74402672.00	63,966,674.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74402672.00	63,966,674.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3190989.00	3,103,510.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3190989.00	3,103,510.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77593661.00	67070184.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77593661.00	67,070,184.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77593661.00	67,070,184.00
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Ж.ӨСӨХБАЯР

Огноо: 2020.02.21

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

Огноо: 2020.02.21

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.21